# МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

**2011 ОНЫ ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

## Төлбөрийн тэнцэл

2011 онд урсгал ба хөрөнгийн данс 4,382 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 4,582 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 18 сая ам.долларын ашигтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр өссөн байна. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн –182 сая ам.доллар байна.

2010 оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 3,649 сая ам.доллараар, санхүүгийн дансны ашиг 2,914 сая ам.доллараар тус тус өссөн байна.
Гадаад валютын улсын нөөц тайлант жилийн эцсийн байдлаар 2,450.6 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 6.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

**Дүрсэлэл 1. Төлбөрийн тэнцэл**




## Гадаад хөрөнгө оруулалтын позиц (IIP)

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 6,126 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 18,440 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц 2011 оны эцэст 12,314 сая ам.долларын сөрөг үлдэгдэлтэй буюу богино позицтой байна.
Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулах бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 90% буюу 5,824 сая ам.доллараар өссөн.

Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 5,746 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалын богино позиц 404 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ.

**Дүрсэлэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц**




## Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2011 оны эцэст 10,908 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 53%-иар буюу 3,781 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрийн гадаад өр 9%-иар буюу 161 сая ам.доллараар өсч 2,043 сая ам.долларт,
- Төв банкны гадаад өглөг 2%-иар буюу 6 сая ам.доллараар буурч 268 сая ам.долларт,
- Банкуудын гадаад өр 44%-иар буюу 228 сая ам.доллараар өсч 740 сая ам.долларт,
- Бусад сектор (ААН)-ын гадаад өр 29%-иар буюу 430 сая ам.доллараар өсч 1,905 сая ам.долларт,
- Гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эх үүсвэр 99% -иар буюу 2,967 сая ам.доллараар өсч 5,953 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

**Дүрсэлэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл**



# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## УРСГАЛ БА ХӨРӨНГИЙН ДАНС

2011 онд урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 4,382 сая ам.долларт хүрч, алдагдлын хэмжээ 2010 оны мөн үеэс 6 дахин өсчээ.

Энэ нь өнгөрсөн онд 172 сая ам.долларын алдагдалтай байсан барааны данс тайлант онд 2,669 сая ам.долларын алдагдалтай, үйлчилгээний алдагдал 303 сая ам.доллараас 848 сая ам.долларт, анхдагч орлогын алдагдал 598 сая ам.доллараас 1,243 сая ам.долларт хүрч тус тус нэмэгдсэнээр тайлбарлагдаж байна.

## Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 80%-иар өсч 10.8 тэрбум ам.долларт хүрсэн. Барааны худалдааны тэнцэл тайлант хугацаанд 2.7 тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа.

Барааны худалдааны алдагдалтай гарахад тайлант улиралд нефтийн импорт 67%-иар, хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмжийн импорт 114%-иар, бүх төрлийн автомашины импорт 155%-иар өссөн нь тус тус нөлөөлсөн.

## Үйлчилгээний худалдаа

2016 онд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 180%-иар буюу 546 сая ам.доллараар өсч 848 сая ам.долларт хүрсэн.

Алдагдал өсөхөд бусад үйлчилгээний зардал 237 сая ам.доллараар, тээврийн үйлчилгээний зардал 218 сая ам.доллараар, аяллын үйлчилгээний зардал 131 сая ам.доллараар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

## Анхдагч орлого

2011 оны гүйцэтгэлээр анхдагч орлогын данс 1,243 сая ам.долларын алдагдалтай гарч 2010 онтой харьцуулахад алдагдлын хэмжээ 2 дахин буюу 646 сая ам.доллараар өссөн. Тайлант хугацааны голлох төлбөрийг дурьдвал:

- ААН-ийн гадаадын хөрөнгө оруулагчдад 381 сая ам.долларын ногдол ашгийг хуваарилж, хөрөнгө оруулагчдын зээлийн үүсвэрт 283 сая ам.долларын хүү төлсөн,
- ААН-ийн бусад гадаад зээлийн эх үүсвэрт 59 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Банкууд гадаад зээл болон харьяат бусын харилцах, хадгаламжийн дансанд 16 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Төр, хувийн хэвшил хамтдаа бондын эх үүсвэрт 20 сая долларын хүүгийн төлбөрийг төлсөн байна.

## Хоёрдогч орлого

Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 59%-иар буурсан. Үүний зэрэгцээ гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 42.9%-иар өссөн. Ингэснээр ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 76 сая ам.доллар буурсан байна.

**Хүснэгт 1. Урсгал ба хөрөнгийн тэнцэл (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | | | өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | 2010 | 2011 | Дүн | Хувь |
| **I. Урсгал тэнцэл** | **-885** | **-4 512** | **-3 627** | **-410%** |
| *1.1. Бараа* | -172 | -2 669 | -2 497 | 1452% |
| *1.2. Үйлчилгээ* | -303 | -848 | -545 | 180% |
| *1.3. Анхдагч орлого* | -598 | -1 243 | -646 | 108% |
| *1.4. Хоёрдогч орлого* | 187 | 248 | 61 | 33% |
| **II.Хөрөнгийн тэнцэл** | **152** | **130** | **-22** | **-15%** |
| *2.1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгө* | -1 | 0 | 1 | 0% |
| *2.2. Хөрөнгийн шилжүүлэг* | 153 | 130 | -23 | -15% |
| ***Урсгал болон хөрөнгийн дансны тэнцэл*** | *-733* | *-4382* | *-3649* | *498%* |

**Дүрслэл 5. Барааны худалдаа**




**Дүрслэл 6. Үйлчилгээний худалдаа**




**Хүснэгт 2. Ажилчдын гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)**

| | Хүлээн авсан | | | Шилжүүлсэн | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Мөнгөн дүн | Хувийн жин | Өсөлт | Мөнгөн дүн | Хувийн жин | Өсөлт |
| **Солонгос** | 37,059 | 17% ▼ | -35% | 14,034 | 8% ▲ | 87% |
| **Америк** | 25,306 | 12% ▲ | 1% | 52 | 0% ▼ | -100% |
| **Хятад** | 23,561 | 11% ▼ | -32% | 1 | 0% ▼ | -100% |
| **Гонг Конг** | 25,237 | 11% ▲ | 197% | 559 | 0% ▼ | -89% |
| **Англи** | 14,073 | 6% ▼ | -18% | 37,385 | 22% ▲ | 799% |
| **ОХУ** | 11,547 | 5% ▼ | -10% | 1 | 0% ▼ | -100% |
| **Сингапур** | 6,368 | 3% ▲ | 68% | - | 0% ▼ | -100% |
| **Швейцарь** | 10,935 | 5% ▲ | 27% | 421 | 0% ▼ | -56% |
| **Герман** | 8,869 | 4% ▲ | 4% | 4,631 | 3% ▲ | 36% |
| **Япон** | 6,690 | 3% ▼ | -32% | 24 | 0% ▼ | -99% |
| **Бусад** | 49,923 | 23% ▼ | -18% | 109,558 | 66% ▲ | 386% |
| **НИЙТ** | **219,567** | **100%** | | **166,666** | **100%** | |

**Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга, (жилээр, сая ам.доллар)**

| | Жил | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | **2009** | **2010** | **2011** | **Мөнгөн дүн** | **Хувиар** |
| **Ажилчдын гуйвуулга (цэвэр)** | 6.8 | 21.3 | 20.3 | -1.0 | -4.5% |
| **Гаднаас орж ирсэн** | 242.8 | 242.0 | 268.3 | 26.3 | 10.9% |
| **Гадагш шилжүүлсэн** | 130.0 | 181.3 | 259.0 | 77.8 | 42.9% |

# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## САНХҮҮГИЙН ДАНС

Санхүүгийн дансны тэнцэл 2011 онд 4,582 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 175%-иар буюу 2,914 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Энэхүү өсөлт нь шууд хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө оруулалтын дансны эх үүсвэрээс голлон шалтгаалж байна.

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2011 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 4,477 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 175%-иар буюу 2,848 сая ам.доллараар өссөн байна.

Үүнд аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын шууд хөрөнгө оруулагчдаас татсан зээлийн эх үүсвэр өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс цэвэр дүнгээр 2880 сая ам.доллараар өссөнөөр тайлбарлагдаж байна.

Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь авч үзвэл,

- Гонг-Конгоос орж ирсэн хөрөнгө оруулалт 2010 онд 518 сая ам.доллар байсан бол 2011 онд 1,690 сая ам.долларт,
- Сингапур улсын хөрөнгө оруулалт 15 сая ам.доллараас 2011 онд 98 сая ам.долларт хүрч тус тус өссөн, харин
- ОХУ-ын хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 40 сая ам.доллараар буурч 7.8 сая ам.долларт хүрсэн байна.

## Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын дансны ашиг 2011 онд 73 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 822 сая ам.доллараар буурсан. Энэ нь тайлант онд багцын хөрөнгө оруулалтын ашиглалт, эргэн төлөлтийн дүн бага байсантай холбоотой байна.

## Бусад хөрөнгө оруулалт

Тайлант онд төлбөрийн тэнцлийн бусад хөрөнгө оруулалтын данс 33 сая ам.долларын ашигтай гарсан нь банкуудын гадаад актив буюу харьяатуудын бэлэн мөнгө ба харилцах дансны үлдэгдэл 554 сая ам.доллараар, гадаад зээлийн ашиглалт цэвэр дүнгээр 362 сая ам.доллараар нэмэгдсэнтэй холбоотой юм.

## Алдаа ба орхигдуулга

2010 оны жилийн эцэст алдаа ба орхигдуулга үзүүлэлт 182,5 сая ам.доллар гарсан байна.

Уг үзүүлэлт сөрөг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд дотогш чиглэсэн хөрөнгийн урсгал илүү бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.

**Хүснэгт 4. Санхүүгийн тэнцэл (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | Он | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | 2010 | 2011 | Дүн | Хувь |
| **III. Санхүүгийн тэнцэл** | **-1,669** | **-4,582** | **-2,914** | **-175%** |
| *а. Шууд хөрөнгө оруулалт* | -1,629 | -4,477 | -2,848 | -175% |
| *Гадагш хийсэн* | 62 | 95 | 32 | 52% |
| *Монгол Улсад орсон* | 1,691 | 4,571 | 2,880 | -170% |
| *б. Багцын хөрөнгө оруулалт* | -894 | -73 | 822 | 92% |
| *в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл* | 0 | 0 | 0 | 0% |
| *г. Бусад хөрөнгө оруулалт* | 855 | -33 | -888 | -104% |
| *Үүнээс: Худалдааны зээл* | 67 | 369 | 301 | -449% |
| *Бэлэн мөнгө харилцах* | 1,049 | 592 | -458 | -44% |

**Хүснэгт 5. ГШХО, улсаар (сая ам.доллар)**

| № | Үзүүлэлт | Жил | | 2011/2010 | |
|---|---|---|---|---|---|
| | | Дүн | Хувийн жин | Өөрчлөлт | |
| 1 | Австрали | 98,1 | 3% | 54,7 | ▲ |
| 2 | Америк | 282,1 | 9% | 15,6 | ▲ |
| 3 | Англи | 211,6 | 6% | 114,1 | ▲ |
| 4 | Бельги | 36,4 | 1% | 36,0 | ▲ |
| 5 | БНХАУ | 278,1 | 8% | 162,0 | ▲ |
| 6 | Герман | 19,0 | 1% | -7,1 | ▼ |
| 7 | Голланд | 4,0 | 0% | -33,7 | ▼ |
| 8 | Гонг-Конг | 1690,2 | 51% | 1172,6 | ▲ |
| 9 | Канад | 319,5 | 10% | 76,6 | ▲ |
| 10 | Люксенбург | 7,5 | 0% | 2,6 | ▲ |
| 11 | Малайз | 5,5 | 0% | 2,6 | ▲ |
| 12 | ОХУ | 7,8 | 0% | -39,6 | ▼ |
| 13 | Сингапур | 98,2 | 3% | 83,5 | ▲ |
| 14 | Солонгос (өмнөд) | 54,8 | 2% | 22,0 | ▲ |
| 15 | Швейцарь | 39,9 | 1% | 34,2 | ▲ |
| 16 | Япон | 35,4 | 1% | 17,0 | ▲ |
| 17 | Бусад | 108,1 | 3% | 79,4 | ▲ |
| | **Нийт** | **3296,2** | **100%** | **1792,5** | ▲ |

**Дүрслэл 7, Бусад хөрөнгө оруулалт (сая ам.доллар)**



# II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2011 оны эцэст –12,314 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 12.3 тэрбум ам.доллараар их байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат бус оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 6,127 сая ам.доллар байна. Үүний 46%-ийг гадаад валютын албан нөөц, 29%-ийг шууд хөрөнгө оруулалт, 22%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 3%-ийг нь багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 18,440 сая ам.долларт хүрчээ. Үүний 72%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 25% -ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 3%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 55%-ийг буюу 7,380 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 45% буюу 5,953 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оноос 90%-иар буюу 5,824 сая ам.доллараар өссөн байна.

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив –2%-иар буюу 94,7 сая ам.доллараар буурч, гадаад пассив 45%-иар буюу 5,730 сая ам.доллараар өсөнөөр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 5,746 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 233 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 404 сая ам.доллараар, гадаад валютын албан нөөц 559 сая ам.доллараар тус тус өссөнөөр тайлбарлагдаж байна.

Өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, гадаад хөрөнгө оруулалтын богино позиц төлбөрийн тэнцлийн орох, гарах урсгалаар -4,565 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр –1,096 сая ам.доллараар, бусад өөрчлөлтөөр –174 сая ам.доллараар, ханшийн зөрүүгээр +9 сая ам.доллараар өөрчлөгдсөн байна.

Гадаад активын дүн буурсан нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүн буурснаас шалтгаалсан бол гадаад пассивын өсөлт нь мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтын тодруулбал ААН-үүдын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл болон Засгийн газрын урт хугацаат гадаад зээлийн эх үүсвэрийн өсөлтөөр голлон шалтгаалжээ.

**Хүснэгт 7. Позиц (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 12/31/2010 | 12/31/2011 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | дүн | хувь |
| **Гадаад хөрөнгө оруулалтын позиц** | **-6,489** | **-12,314** | **5,824** | **90%** |
| **I. Гадаад актив** | **6,221** | **6,127** | **-95** | -2% |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 2,616 | 1,757 | -859 | -33% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 359 | 202 | -156 | -44% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 00 | 01 | 01 | 3106% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 959 | 1,318 | 359 | 37% |
| 5. Нөөц актив | 2,288 | 2,847 | 559 | 24% |
| **II. Гадаад пассив** | **12,711** | **18,440** | **5,730** | **45%** |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 8,445 | 13,333 | 4,888 | 58% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 487 | 564 | 76 | 16% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 00 | 01 | 01 | 3089% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 3,779 | 4,542 | 764 | 20% |

**Дүрслэл 7. Гадаад актив**




**Дүрслэл 8. Гадаад пассив**



# III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2011 оны эцсийн байдлаар 10,908 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 3,781 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

**Улсын салбар:** Засгийн газрын гадаад өр 161 сая ам.доллараар нэмэгдэж 2,043 сая ам.долларт хүрсэн бол Монголбанкны гадаад өр 6 сая ам.доллараар буурч 268 сая ам.долларт хүрчээ.

**Бусад салбар:** Банк, бусад секторын болон гадаадын хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн жилийн хугацаанд 3,625 сая ам.доллараар өсч 8,598 сая ам.долларт хүрээд байна.

**Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 12/31/10 | 12/31/11 | өөрчлөлт | | * %2 |
|---|---|---|---|---|---|
| | | | *дүн* | *хувь* | |
| **Нийт гадаад өр** | **7 128** | **10 908** | **3 781** | **53%** | **100%** |
| **I. Засгийн газар** | **1 882** | **2 043** | **161** | **9%** | **19%** |
| **II. Төв банк** | **274** | **268** | **-6** | **-2%** | **2%** |
| **III. Банк** | **512** | **740** | **228** | **45%** | **7%** |
| Богино хугацаат | 59 | 111 | 52 | 88% | 1% |
| Урт хугацаат | 453 | 629 | 176 | 39% | 6% |
| **IV. Бусад сектор** | **1 474** | **1 905** | **430** | **29%** | **17%** |
| Богино хугацаат | 602 | 726 | 124 | 21% | 7% |
| Урт хугацаат | 872 | 1 179 | 307 | 35% | 11% |
| **V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл** | **2 986** | **5 953** | **2 967** | **99%** | **55%** |

## Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2011 оны эцэст 740 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 44%-иар буюу 228 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 35%-ийг бонд өрийн бичиг, 33%-ийг урт хугацаат зээл, 18%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг, 15%-ийг богино хугацаат зээл тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт хугацаат зээлийн үлдэгдэл 241 сая ам.доллар, богино хугацаат зээлийн үлдэгдэл 111 сая ам.долларт тус тус хүрчээ.

**Дүрслэл 12. Банкны салбарын гадаад зээл**




## Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2011 оны эцэст 7,858 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 3,397 сая ам.доллараар өссөн.

Салбарын нийт зээлийн 54% буюу 5,953 сая ам.долларын эх үүсвэр нь ААН-үүдийн гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Энэхүү зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.

ААН-үүдийн экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 350 сая ам.доллар болсон байна.

**Дүрслэл 13. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл**




**Мэдээллийн эх сурвалж:**

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

# ХАВСРАЛТ 1.  МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

| Үзүүлэлт | Он | | | Өөрчлөлт | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2009 | 2010 | 2011 | Дүн | 2010/09 | Дүн | 2011/10 |
| **I. УРСГАЛ ДАНС** | **-342** | **-885** | **-4512** | **-544** | **159%** | **-3627** | **-410%** |
| **Бараа ба үйлчилгээний худалдаа** | -332 | -475 | -3,517 | -143 | 43% | -3,042 | -641% |
| **Кредит** | 2,298 | 3,394 | 4,577 | 1,095 | 48% | 1,183 | 35% |
| **Дебет** | 2,630 | 3,869 | 8,094 | 1,238 | 47% | 4,226 | 109% |
| **1. Бараа** | -178 | -172 | -2,669 | 6 | -3% | -2,497 | -1452% |
| 1.1 Экспорт Ф.О.Б (кредит) | 1,881 | 2,908 | 4,056 | 1,027 | 55% | 1,148 | 39% |
| 1.2 Импорт Ф.О.Б (дебит) | 2,059 | 3,080 | 6,725 | 1,021 | 50% | 3,645 | 118% |
| **2. Үйлчилгээ** | -154 | -303 | -848 | -149 | 97% | -545 | -180% |
| Кредит | 418 | 486 | 521 | 68 | 16% | 35 | 7% |
| Дебет | 571 | 789 | 1,369 | 217 | 38% | 580 | 74% |
| 2.1 Тээвэр | -68 | -111 | -293 | -43 | 63% | -182 | -165% |
| Кредит | 136 | 175 | 210 | 39 | 28% | 36 | 21% |
| Дебит | 204 | 285 | 503 | 81 | 40% | 218 | 76% |
| 2.2 Аялал | 25 | -21 | -240 | -46 | -185% | -219 | -1031% |
| Кредит | 235 | 244 | 156 | 9 | 4% | -88 | -36% |
| Дебит | 210 | 265 | 396 | 55 | 26% | 131 | 49% |
| 2.3 Бусад үйлчилгээ | -111 | -171 | -315 | -60 | 54% | -144 | -84% |
| Кредит | 46 | 67 | 154 | 21 | 45% | 87 | 130% |
| Дебит | 157 | 238 | 470 | 81 | 51% | 232 | 97% |
| **3. Анхдагч орлого** | -195 | -598 | -1,243 | -402 | 206% | -646 | -108% |
| Кредит | 24 | 30 | 43 | 5 | 21% | 14 | 46% |
| Дебет | 220 | 627 | 1,286 | 407 | 185% | 659 | 105% |
| 3.1 Ажилчдын цалин | -4 | -32 | -116 | -28 | 717% | -83 | -258% |
| 3.2 Хөрөнгө оруулалтын орлого | -191 | -565 | -1,128 | -374 | 195% | -562 | -99% |
| 3.3 Бусад | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| **4. Хоёрдогч орлого** | 186 | 187 | 248 | 1 | 1% | 61 | 33% |
| Кредит | 260 | 309 | 430 | 49 | 19% | 121 | 39% |
| Дебит | 75 | 122 | 182 | 48 | 64% | 60 | 49% |
| үүнээс: Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 60 | 33 | 29 | -27 | -45% | -4 | -12% |
| Бусад байгууллага | 126 | 154 | 219 | 28 | 22% | 65 | 42% |
| **II. ХӨРӨНГИЙН ДАНС** | **160** | **152** | **130** | **-8** | **-5%** | **-22** | **-15%** |
| **1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (Дт)/ бууралт (Кр)** | 0 | -1 | 0 | -1 | 0% | 1 | 0% |
| Кредит | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| Дебет | 0 | 1 | 0 | 1 | 0% | -1 | 0% |
| **2. Хөрөнгийн шилжүүлэг** | 160 | 153 | 130 | -8 | -5% | -23 | -15% |
| Кредит | 160 | 153 | 134 | -8 | -5% | -19 | -12% |
| Дебет | 0 | 0 | 4 | 0 | #DIV/0! | 4 | 3798% |
| | 0 | 0 | 0 | | | | |
| **Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (ээлдүүлэг + / ээллэг -)** | **-181** | **-733** | **-4,382** | **-552** | **304%** | **-3,649** | **-498%** |
| **III. САНХҮҮГИЙН ДАНС** | **-608** | **-1669** | **-4582** | **-1060** | **174%** | **-2914** | **-175%** |
| **Санхүүгийн дансны тэнцэл (ээлдүүлэг + / ээллэг -)** | **-608** | **-1,669** | **-4,582** | **-1,060** | **174%** | **-2,914** | **-175%** |
| **1. Шууд хөрөнгө оруулалт** | -570 | -1,629 | -4,477 | -1,059 | 186% | -2,848 | -175% |
| 1.1 Актив | 54 | 62 | 95 | 9 | 16% | 32 | 52% |
| 1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 0 | 47 | 61 | 47 | -12206% | 14 | 31% |
| 1.1.2 Өрийн хэрэгсэл | 54 | 16 | 34 | -39 | -71% | 18 | 115% |
| 1.2 Пассив | 624 | 1,691 | 4,571 | 1,068 | 171% | 2,880 | 170% |
| 1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 488 | 1,331 | 1,623 | 843 | 173% | 292 | 22% |
| 1.2.2 Өрийн хэрэгсэл | 136 | 360 | 2,948 | 225 | 166% | 2,588 | 718% |
| **2. Багцын хөрөнгө оруулалт** | 82 | -894 | -73 | -977 | -1189% | 822 | 92% |
| 2.1 Актив | 139 | -143 | -17 | -282 | -203% | 127 | 88% |
| 2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 6 | 13 | 28 | 6 | 101% | 15 | 118% |
| 2.1.2  Өрийн бичиг | 132 | -156 | -45 | -289 | x29 | 111 | 71% |
| 2.2 Пассив | 57 | 751 | 56 | 694 | 1224% | -695 | -93% |
| 2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 4 | 680 | 7 | 677 | x63 | -674 | -99% |
| 2.2.2  Өрийн бичиг | 53 | 71 | 49 | 18 | 33% | -21 | -30% |
| 2.2.2.1 Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 2.2.2.2 Урт хугацаат | 53 | 71 | 49 | 18 | 33% | -21 | -30% |
| **3. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд** | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 3.1 Актив | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 3.2 Пассив | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| **4. Бусад хөрөнгө оруулалт** | -121 | 855 | -33 | 975 | -809% | -888 | -104% |
| 4.1 Актив | 145 | 1,040 | 698 | 895 | 618% | -342 | -33% |
| 4.1.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах | 161 | 1,041 | 486 | 880 | 547% | -555 | -53% |
| 4.1.3 Зээл | -5 | -4 | -6 | 1 | x14 | -1 | -28% |
| 4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | -11 | 4 | 218 | 15 | -137% | 214 | 5406% |
| 4.1.5.1 Богино хугацаат | -11 | 4 | 218 | 15 | -137% | 214 | 5406% |
| 4.1.5.2 Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.1.6 Бусад авлага | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.2 Пассив | 265 | 185 | 732 | -80 | -30% | 546 | 295% |
| 4.2.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах | -45 | 9 | 106 | 54 | -120% | 97 | 1104% |
| 4.2.3 Зээл | 231 | 114 | 475 | -117 | -51% | 362 | 319% |
| 4.2.3.1 Төв банк | -2 | -1 | -2 | 0 | -15% | 0 | 0% |
| 4.2.3.2  Хадгаламжийн байгууллагууд | 60 | -9 | 98 | -69 | -115% | 106 | 1198% |
| 4.2.3.3.1 Богино хугацаат | 29 | -51 | 31 | -80 | -278% | 83 | 161% |
| 4.2.3.3.2 Урт хугацаат | 31 | 43 | 66 | 11 | 36% | 24 | 56% |
| 4.2.3.3 Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 150 | 10 | 140 | -140 | -94% | 130 | 1364% |
| 4.2.3.4  Бусад салбар | 22 | 114 | 239 | 92 | 413% | 125 | 110% |
| 4.2.3.4.1 Богино хугацаат | 5 | -19 | -35 | -24 | -475% | -17 | -89% |
| 4.2.3.4.2 Урт хугацаат | 17 | 133 | 275 | 116 | 671% | 142 | 107% |
| 4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | 4 | 63 | 150 | 59 | 1642% | 87 | 138% |
| 4.2.5.1 Богино хугацаат | 4 | 63 | 150 | 59 | 1642% | 87 | 138% |
| 4.2.5.2 Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.2.6 Бусад авлага | 76 | 0 | 0 | -76 | 0% | 0 | 0% |
| 4.2.7 Зээлжих тусгай эрх /Урт хугацаат/ | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| **IV. Алдаа болон орхигдуулга** | **128** | **-62** | **-182** | **-191** | **-149%** | **-120** | **-193%** |
| ***Төлбөрийн тэнцлийн нийт дүн*** | ***556*** | ***873*** | ***18*** | ***318*** | ***57%*** | ***-855*** | ***-98%*** |
| **V. НӨӨЦ ХӨРӨНГӨ** | **556** | **873** | **18** | **318** | **-98%** | **-855** | **-98%** |
| 1. ГВУН | 713 | 892 | 14 | 179 | -98% | -878 | -98% |
| 2. ОУВС-гийн зээл | 157 | 19 | -4 | -139 | -121% | -23 | -121% |
| 3. Тусгай санхүүжилт | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |

** [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.*

*Эх сурвалж:* Монголбанк

## ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

| Үзүүлэлт | 12/31/2010 | 3/31/2011 | 6/30/2011 | 9/30/2011 | 12/31/2011 | 14.06.30 |
|---|---|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц** | **-6,489** | **-12,314** | **-19,238** | **-24,642** | **-25,727** | **-26,368** |
| | | | | | | |
| **Актив** | **6,221** | **6,127** | **6,753** | **4,340** | **4,413** | **3,848** |
| **Шууд хөрөнгө оруулалт** | **2,616** | **1,757** | **883** | **351** | **356** | **363** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | **2,595** | **1,704** | **817** | **282** | **286** | **291** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 2,595 | 1,704 | 817 | 282 | 286 | 291 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| *үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| *үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | **20** | **54** | **66** | **69** | **71** | **72** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 20 | 54 | 66 | 69 | 71 | 71 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | **359** | **202** | **485** | **370** | **291** | **259** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 308 | 196 | 479 | 365 | 286 | 251 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 0 | 0 | 0 | 3 | 2 | 3 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | -0 | 0 |
| Бусад салбарууд | 308 | 196 | 479 | 362 | 2 | 249 |
| Бусад санхүүгийн байгууллага | 4 | 32 | 77 | 92 | 0 | 105 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 304 | 165 | 402 | 270 | 0 | 144 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 | 283 | 0 |
| Бүртгэлтэй | 0 | 0 | 0 | 0 | 97 | 0 |
| Бүртгэлгүй | 0 | 0 | 0 | 0 | 2 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 3 | 0 |
| **Өрийн бичиг** | 51 | 6 | 6 | 6 | 6 | 7 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 51 | 6 | 6 | 6 | 6 | 7 |
| Богино хугацаат | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 |
| Урт хугацаат | 45 | 0 | 0 | -0 | -0 | 1 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 45 | -0 | -0 | -0 | -0 | -0 |
| **Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | **0** | **1** | **0** | **49** | **164** | **160** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 0 | 1 | 0 | 49 | 164 | 160 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад санхүүгийн байгууллагууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Форвард хэлбэрийн хэлцлүүд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Ажилчдын хувьцааны опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | **959** | **1,318** | **1,259** | **1,404** | **1,658** | **1,748** |
| **Бусад хөрөнгө** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | **839** | **1,033** | **896** | **1,100** | **1,301** | **1,331** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 503 | 500 | 530 | 489 | 570 | 495 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 335 | 533 | 366 | 611 | 731 | 836 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Зээл** | **18** | **14** | **15** | **6** | **5** | **7** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 18 | 9 | 15 | 2 | 2 | 4 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 5 | 0 | 3 | 3 | 2 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 5 | 0 | 3 | 3 | 2 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | **101** | **271** | **348** | **298** | **352** | **410** |
| **Бусад дансны авлага/өглөг** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нөөц хөрөнгө** | **2,288** | **2,847** | **4,126** | **2,166** | **1,943** | **1,318** |

*Эх сурвалж:* Монголбанк

## Үргэлжлэл.

| Үзүүлэлт | 12/31/2010 | 3/31/2011 | 6/30/2011 | 9/30/2011 | 12/31/2011 |
|---|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц** | -6,489 | -7,485 | -8,865 | -10,706 | -12,314 |
| **Өр төлбөр** | **12,711** | **14,162** | **15,567** | **16,635** | **18,440** |
| **Шууд хөрөнгө оруулалт** | **8,445** | **9,776** | **10,924** | **12,004** | **13,333** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | **5,459** | **6,090** | **6,359** | **6,783** | **7,380** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 5,459 | 6,090 | 6,359 | 6,783 | 7,380 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | **2,986** | **3,686** | **4,565** | **5,222** | **5,953** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 2,986 | 3,686 | 4,565 | 5,222 | 5,953 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | **487** | **548** | **526** | **553** | **564** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 124 | 179 | 152 | 161 | 151 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 11 | 11 | 11 | 11 | 11 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 113 | 168 | 141 | 150 | 140 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлтэй | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлгүй | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| үүнээс:  Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн бичиг** | 364 | 368 | 374 | 392 | 413 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 242 | 246 | 245 | 258 | 258 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 242 | 246 | 245 | 258 | 258 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 114 | 114 | 121 | 125 | 127 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 114 | 114 | 121 | 125 | 127 |
| Бусад салбарууд | 8 | 8 | 8 | 8 | 28 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 8 | 8 | 8 | 8 | 28 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | **0** | **5** | **0** | **0** | **1** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 0 | 5 | 0 | 0 | 1 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | **3,779** | **3,833** | **4,117** | **4,077** | **4,542** |
| **Бусад хөрөнгө** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | **35** | **39** | **63** | **64** | **130** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 35 | 39 | 63 | 64 | 130 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 35 | 39 | 63 | 64 | 130 |
| үүнээс: Банк хоорондын позиц | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Зээл** | **3,564** | **3,622** | **3,853** | **3,853** | **4,063** |
| Төв банк | 274 | 279 | 280 | 275 | 268 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 235 | 231 | 280 | 312 | 352 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 1,769 | 1,778 | 1,827 | 1,808 | 1,917 |
| Бусад салбарууд | 1,287 | 1,333 | 1,466 | 1,458 | 1,526 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | **180** | **173** | **201** | **160** | **350** |
| **Бусад дансны авлага/өглөг** | **0** | **0** | **0** | **0** | **0** |

*Эх сурвалж:* Монголбанк

**ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 12/31/2010 | 03/31/2011 | 06/30/2011 | 09/30/2011 | 12/31/2011 |
|---|---|---|---|---|---|
| Засгийн газар | 1 882,2 | 1 892,7 | 1 947,9 | 1 933,4 | 2 043,3 |
| Төвбанк | 273,6 | 279,1 | 280,1 | 275,4 | 267,7 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 512,0 | 516,3 | 587,9 | 633,8 | 739,8 |
| Бусад салбарууд | 1 474,3 | 1 513,6 | 1 674,9 | 1 626,5 | 1 904,7 |
| Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг | 2 985,7 | 3 685,8 | 4 565,4 | 5 221,8 | 5 952,8 |
| **Нийт гадаад өр** | **7 127,8** | **7 887,4** | **9 056,2** | **9 690,9** | **10 908,3** |

*Эх сурвалж:* Монголбанк